



АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛИАС...

Хяналт шинжилгээ, үнэлгээний
мэргэжилтэн Б.Биндэръяа

Авлига гэж юу вэ?

- o Албан тушаалын эрх мэдлээ ашиглан....
- o - Хувийн ашиг хонжоо олох,
- o - Бусдад болон өөртөө давуу байдал олгох,
- o - Хууль бус үйлдэл хийхийг **авлига** гэнэ.

Хуулийн үйлчлэлд хамаарах этгээд

- Төрийн улс төрийн, захиргааны, тусгай албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан;
- Төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтан болон ерөнхий нягтлан бодогч, ахлах нягтлан бодогч;
- Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах болон компанийн эрх бүхий албан тушаалтан;
- Олон нийтийн радио, телевизийн үндэсний зөвлөлийн дарга, гишүүн, ерөнхий захирал;
- Улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт авч төрийн тодорхой чиг үүргийг хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын удирдах албан тушаалтан;
- Монгол улсын ерөнхийлөгч, улсын их хурал, бүх шатны иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуульд нэр дэвшигч;
- Бүх шатны иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга, төлөөлөгч;

Олон нийтийг соён гэгээрүүлэхэд төрийн болон төрийн бус байгуулага, иргэд ямар үүрэг хүлээх вэ?

Захиргааны байгууллагын шийдвэр гаргах ажиллагаа

Захиргааны байгууллага өөрийн санаачлагаар хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх, дээд шатны захиргааны байгууллагаас өгсөн үүргийг биелүүлэх, эсхүл оролцогчийн гаргасан өргөдөл, гомдлыг үндэслэн захиргааны шийдвэр гаргах ажиллагааг эхлүүлнэ.






**Бүх шатны төрийн
байгууллагын захиргааны
шийдвэрт иргэд олон нийтийн
санал тусгах нөхцөл
бүрдүүлэх.**



**Авлигын эсрэг хууль
тогтоомжийг олон
төрлөөр иргэдэд
сурталчлах**

Авлигаас урьдчилан сэргийлэхэд Төрийн байгууллага юу хийх вэ?

- . Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх
- . Төрийн бодлого, шийдвэр боловсруулах, шийдвэр гаргахын өмнө олон нийтэд нээлттэй хэлэлцүүлэх, эрх олгох, зөвшөөрөл олгоход ил тод байж, иргэдийн хяналтыг тодорхой болгон иргэдтэй хамтран ажиллах.
- . Төсвийн орлого, зарлага, бусад үйл ажиллагаа ил тод, нээлттэй байх, иргэд танилцах боломжтой байх.
- . Иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх, үйл ажиллагааны шат дамжлагыг цөөрүүлэх





Авлигын шалтгаан
нөхцөлийг илрүүлэн,
арилгах, таслан зогсоох
арга хэмжээ авах

Төрийн бус байгууллага ямар үүрэг хүлээх вэ?

Төрийн бус байгууллага нь санхүүгийн
тайлангаа ил тод мэдээлж байх;

Албан тушаалтанд хориглох зүйл нь?

- Албан үүргээ зохих ёсоор гүйцэтгэж байгаа төрийн албан хаагчид дарамт, шахалт үзүүлэх, хөндлөнгөөс оролцох, нөлөөлөх;
- Бусдад шан харамж өгөх, өгөхөөр амлах, зуучлах;
- Албан үүргээ гүйцэтгэхдээ хууль бусаар аливаа хувь хүн, хуулийн этгээдэд давуу байдал олгох, олгохоор амлах, бусдын эрхийг хязгаарлах;
- Төсвийн болон хандив, тусламжийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах;
- Албан үүргээ гүйцэтгэх, эсхүл гүйцэтгэхгүй байхтай холбогдуулан бусдаас шан харамж шаардах;
- Албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах, хэтрүүлэх;
- Албан тушаалын байдлаа ашиглан эд хөрөнгө олж авах, давуу эрх эдлэх;
- Үндэслэлгүйгээр хөрөнгөжихийг тус тус хоригложээ.

Авлигын тухай хэрхэн хаана мэдэгдэх вэ?



Төрийн албан хаагч нь албан үүрэг гүйцэтгэх явцдаа олж мэдсэн авлигын талаарх мэдээллийг Авлигатай тэмцэх газарт нэн даруй мэдээлэх үүрэгтэй.

Иргэн нь авлигын асуудлаар Авлигатай тэмцэх газарт өргөдөл, гомдол гаргаж, мэдээлэл өгч болно



**АНХААРАЛ ХАНДУУЛСАНД
БАЯРЛАЛАА**